- 2020 оны 78 дугаар тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- 2020 оны 114 дүгээр тогтоол “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- 2020 оны 151 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”
- 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”
- 2020 оны 168 дугаар тогтоол “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай”
- 2020 оны 183 дугаар тогтоол “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

3.3 нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь 2011 онд боловсруулан батлагдсан ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцэхгүй байна.

Эрүүл мэндийн яамнаас хяналт шинжилгээ хийгдээгүй, аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгт 2 удаа хамрагдаж, “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний хэрэгжилтээр 97.95%-иар үнэлэгдэж, аймгийн байгууллагуудаас ажлаараа тэргүүн байранд шалгарсан.

“Хүртээмжтэй чанартай төрийн үйлчилгээний жил” урианы жилийн хүрээнд “Чанарын менежментийн тогтолцоо” ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж, 3 жилийн батламж авсан.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас зарласан “Сувилагч, эх баригчийн жил-2020” уриаг салбарын хэмжээнд дэвшүүлэн ажиллаж, Эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндийн дэмжих аймгийн хөтөлбөр, Сувилагч хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг “Тохиолдлын удирдлагын тогтолцоо”-нд шилжүүлэн бэлэн байдлыг ханган ажилласнаар одоог хүртэл халдварт өвчин манай аймагт бүртгэгдээгүй

байгаа ба цар тахал, халдварт өвчний үед хэрэглэх хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн нөөцийг бүрдүүлсэн байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр ОБГ, МХГ-тай хамтран 26 сумын Эрүүл мэндийн төв, сумдын шуурхай штабын өндөржүүлсэн бэлэн байдлын үйл ажиллагаатай танилцан, нөхцөл байдлын үнэлгээ хийж, зөвлөн тусалж ажилласан байна.

Эрүүл мэндийн газрын хяналт шинжилгээ үнэлгээний баг нь Мөнгөнморьт, Эрдэнэ, Баянжаргалан, Борнуур, Баянчандмань сумдад ажиллаж, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, заавар чиглэл өгч ажилласан байна.

Эрүүл мэндийн газрын даргын 2020.01.30-ны өдрийн А/06 тоот тушаалаар Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Дотоод хяналтын баг нь 2020 онд 4 зорилт 13 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан байгууллагын даргаар батлуулсан байна.

Дотоод хяналтын багийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой шатахууны зардал, байгууллагын худалдан авах үйл ажиллагаа, санхүүгийн зарцуулалт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийхээр тусгасан байна.

Байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, шилэн дансны мэдээлэл, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл хооллолтын зөвлөгөө өгөх кабинетын үйл ажиллагаанд нийт 5 удаа дотоод аудит хийсэн байна. Дотоод хяналтын ажлын тайланг удирдлагуудад танилцуулдаг. Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн тухай тайланг аймгийн санхүүгийн хяналт аудитын албанд хүргүүлсэн байна.

Шалгалтаар шатахуун зарцуулалтад зөрчил илрээгүй, санхүүгийн зарцуулалт үлдэгдэл нөөцөд тооллого хийхэд малгай-7, алчуур-2, маск-223, халууны шил-4, мэс заслын бээлий-53, углааш-6, үзлэгийн бээлий-53 ширхэг тус тус илүү гарч, илүү гарсан нөөцийг орлогод авхуулсан, шилэн дансны мэдээлэлд 2 удаа шалгалт хийхэд 2 зөрчил илэрсэнд зөвлөмж өгч ажилласан байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,276,334.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,763.3 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагатай гэж үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тооцсон суурь үзүүлэлт нийт орлогын дүн өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн шатны нийт орлогын 3,015,037.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 30,150.4 мянган төгрөгөөр дахин тооцов

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 142,958.2 мянган төгрөгөөр буюу 13,41 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	2,150.0	2,150.0
Бараа материал	92,774.6	320,896.1	228,121.5
Үндсэн хөрөнгө	973,533.6	886,220.3	(87,313.3)
Нийт хөрөнгө	1,066,308.2	1,209,266.4	142,958.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,066,308.2	1,209,266.4	142,958.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,066,308.2	1,209,266.4	142,958.2

Мөнгөн хөрөнгө данс нь оны эхэнд болон эцэст 0 үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Энэ нь төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 1,854.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Авлага дансны оны эхэнд 0 үлдэгдэлтэй байсан оны эцсийн үлдэгдэл 2,150.0 мянган төгрөг болж өссөн байна. Авлага дансны үлдэгдэлд 2020 онд шинээр үүссэн авлага байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 320,896.1 мянган төгрөг болж 228,121.5 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал дансны үлдэгдэл 169,040.7 мянган төгрөгөөр, бусад хангамжийн материал 58,123.2 мянган төгрөгөөр тус тус өссөнөөс шалтгаалжээ.

Бараа материалын эм боох материал болон бусад хангамжийн материалын дансны үлдэгдэл өссөн нь цар тахлаас урьдчилан сэргийлэх бэлтгэл ажлын хүрээнд 158,592.2 мянган төгрөгөөр ковид тестийг бэлтгэсэн, тандалт сэргийлэлтийн төвийн багаж, хэрэгслийг нөөцөлж бэлтгэсэн нь нөлөөлж байна. Энэ нь Ковид-19-н урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдаж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 886,220.3 мянган төгрөг болж 87,313.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 8,147.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 95,461.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Биет бус хөрөнгөнд нэмэгдсэн, хасагдсан өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс үлдэгдэл оны эхэнд болон эцэст 0 төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,209,266.4 мянган төгрөг болж 142,958.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлогын дүн 3,015,037.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 929,495.3 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан

орлого Ковид-19 цар тахалтай холбогдон дархлаажуулалтын сангаас олгодог вакцин, эм бэлдмэлийн орлого өмнөх оноос 143,139.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба урсгал үйл ажиллагааны санхүүжилт 845,583.5 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Нийт зардал төсвийн гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлтээр өмнөх оноос 854,350.7 мянган төгрөгөөр буюу 58,0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэл, норматив зардал, бусад урсгал шилжүүлэг буюу тэтгэмжийн зардлууд байна.

Энэ нь орон тоонд өөрчлөлт ороогүй ч цалин нэмэгдэл хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 105,309.9 мянган төгрөгөөр, норматив зардал 421,900.7 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 132,939.7 мянган төгрөгөөр, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг 25,579.1 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж 37,964.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй болно.

3.6. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2019 оны батлагдсан төсвөөс 776,854.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,255,302.7 мянган төгрөгөөр төлөвлөж, цалин, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 249,774.9 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарах болон 5 жил тутамд олгох тэтгэмжийн зардлыг 74,978.0 мянган төгрөгөөр, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлыг 370,713.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн 2020 оны төсвийн төслөөс 73,729.2 мянган төгрөгөөр, 2019 оны төсвөөс 845,583.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 2,329,031.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төсвийн төсөлд тусгасан норматив зардал буюу эм, эмнэлгийн хэрэгсэл зардлыг 421,900.0 мянган төгрөгөөр, цалин, шимтгэлийн зардлыг 97,987.2 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарах болон 5 жил тутамд олгох тэтгэмжийн зардлыг 196,420.1 мянган төгрөг гэх зэргээр нэмэгдүүлж, хөтөлбөр төсөл арга хэмжээний зардлыг 230,235.5 мянган төгрөгөөр хассанаас шалтгаалсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант 2020 онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,329,031.9 мянган төгрөгийн төсөв авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,329,031.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, урсгал үйл ажиллагаанд 2,327,177.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 1,854.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,327,177.9 мянган төгрөг буюу 99.9 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.6-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар Монголын сумын эмч мэргэжилтний холбооноос сорьц тээвэрлэлтийн зардал, Сүрьеэгийн үзлэгийн зардалд 26,028.6 мянган төгрөг, ДЭМБ-аас сургалтын зардалд 15,222.0 мянган төгрөг, Айвико интернэшнль ХХК-аас Чанарын тогтолцоо баталгаажуулалтын үнэнд 3,500.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын захирамжаар Нүүдлийн амбулаторийн үзлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн зардалд, эрүүл мэнд хөгжлийн зөвлөгөөн, Ковид цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 138,546.8 мянган төгрөг, ЭМЯ, НЭМҮТ-өөс 7,155.8 мянган төгрөгийн орлогыг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 3,649.0 мянган төгрөгийн орлого, нийт 194,102.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэн зарцуулсан байна.

3.7. шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаандаа 147 мэдээллийг байршуулсан ба шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахтай холбоотой зөрчилтэй асуудалд зөвлөмж өгч ажилласан.

3.8. өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага нь Зөрчилгүй санал дүгнэлттэй шалгагдаж, 1,000.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2 зөвлөмж өгөгдсөн байна. Төлбөрийн актыг барагдуулан, зөвлөмжийн хэрэгжилтийг 2020.06.10-ний №1/501 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.9. аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,145,693.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,069,670.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 405.6 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 8,772.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 66,844.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх оны үзүүлэлт нийт орлого 1,117,536.9 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны үр дүн 1,385.9 мянган

- төгрөгөөр, нийт 1,118,922.8 мянган төгрөгөөр дутуу зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залруулав.
- Бусад хангамжийн материалын 3547004 дансанд буруу ангилж, бүртгэсэн 285,085.4 мянган төгрөгийн тендерийн эм, эмнэлгийн хэрэгслийг аудитын явцад залруулав.
 - Санхүүгийн үр дүнгийн тайланд 570,814.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг бөөн дүнгээр, үйл ажиллагааны зардалд 16,719.3 мянган төгрөгийг зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залруулав.
 - Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан 12,591.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дансны бичилтийг аудитын явцад залруулав.
 - Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,673.0 мянган төгрөгийг буруу ангилан тайлагнасан, аймгийн Засаг даргын захирамжаар Ковид-19 цар тахалтай холбогдуулан ОБГ-аас ирүүлсэн 55,169.4 мянган төгрөгийн мөнгөн хандивыг судалгаанд тайлагнаагүй байсныг залруулав.
 - Судалгааны Д301/02 маягтаар авто машинд зарцуулсан 6,694.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардлыг орхигдуулсан, шатахууны зардал зөрүүтэй байсныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил гараагүй болно.

- Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2020 оны батлагдсан 39 орон тоог 12 орон тоогоор /үүнээс 7 албан тушаалыг хавсран гүйцэтгэж/ хэтрүүлэн ажилласан. Хавсран ажилласны нэмэгдлийг олгохдоо тухайн ажилтны үндсэн цалингаас бодож олгоогүйгээс 3 албан тушаалтанд 405.6 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-д "Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил, үүргийг гүйцэтгэсэн, шөнийн болон илүү цагаар ажилласан бол үндсэн цалингаас нь тооцон нэмэгдэл хөлс олгоно" гэж заасныг хэрэгжүүлж, ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ЭМГ-ын стандартад нийцсэн орон тоог Сангийн яамнаас сүүлийн жилүүдэд өөрчлөн батлаагүйгээс батлагдсан орон тоо хэтэрч байгаа талаар гаргасан тайлбарыг ҮАГ-т уламжлан, зөрүүтэй олгосон 405.6 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

- Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан худалдан авах гэрээг шалгахад шатахуун, цахилгаан, бичиг хэрэг, сурталчилгааны зардлыг 6 компанитай, эм эмнэлгийн хэрэгслийг 3 компанитай хийснээс 2 нь нэг удаагийн худалдан авалтын гэрээ, нөгөө нь хугацаа хэтэрсэн, гэрээний нөхцөл хангалтгүй, гэрээ дүгнээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ТБОНӨХБАҮХАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "тендер шалгаруулалт" гэж хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг энэ хуульд заасан

журмын дагуу шалгаруулж, бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох, гэрээ байгуулах ажиллагааг” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага өгөв.

3. Санхүүгийн тайлангаарх 2,150.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт баталгаажуулаагүй зөвхөн 6 байгууллагатай тооцоо нийлсэн. Тооцоо нийлсэн актад тооцооны баримтын жагсаалтыг бичээгүй, он сар, үлдэгдэл бичигдээгүй, ХӨСҮТ-тэй тооцоо нийлсэн актын мэдээлэл 6,622.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай болон санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага өгөв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 66,844.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад Сангийн яамнаас тус байгууллагын цалингийн санг жил бүр нэмэгдүүлдэг ч, бүтэц, орон тоог сүүлийн жилүүдэд өөрчлөөгүй байна. Сангийн сайдын тушаал, стандартад зааснаар 54 орон тоотойгоор ажиллахаас 39 орон тоо хэвээр батлагдсан, ажлын зайлшгүй шаардлагаар батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллаж байгаа талаар тайлбар ирүүлсэн. Аудитаар ЭМС-ын баталсан бүтэц, үйл ажиллагаанд тохирсон орон тоог батлуулах талаар холбогдох газарт хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх болсон тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Санхүүжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Аймгийн ЭМГ-ын даргын 2020.12.22-ний өдрийн а/98 тоот тушаалаар 2020 онд Эрүүл мэндийн газарт батлагдсан сумдын эмийн төсвөөс хэмнэгдсэн үлдэгдэл 66,844.7 мянган төгрөгийг 26 сумын Хүн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн дансанд эмийн төсвийн үлдэгдэл гэж шилжүүлсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, мөн хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэж заасантай болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Эрсдэл:

Эрүүл мэндийн газар нь эм, эмнэлгийн хэрэгслийг цаг хугацаанд нь нийлүүлэх үүргээ гүйцэтгээгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Эм, эмнэлгийн хэрэгслийн тендер сонгон шалгаруулалт, шалгарсан компаниудтай байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилтэд тухай бүрд хяналт тавих ба гэрээг дүгнэж хариуцлага тооцон ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Эм нийлүүлэгч байгууллагуудаас 40.6 сая төгрөгийн нийлүүлэлт цар тахалтай холбогдон хийгдээгүй, сумдад өр үүссэн, цар тахлын үед нэмэлтээр бэлэн байдал хангах урьдчилан сэргийлэх үүднээс сумдад шилжүүлсэн гэсэн тайлбар өгөв.

Анхан шатны баримтжуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эм эмнэлгийн хэрэгсэл данс оны эцэст 204,766.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 5.7 дахин өссөн байна. Эмийн зарлагын гүйлгээг журналын дүнгээс хөөн шалгахад зөрүүтэй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн анхан шатны баримт алдаатай, цахим баримтаар бүрэн баталгаажаагүй, 26 сумын Эрүүл мэндийн төвд нийлүүлсэн тендерийн эм, эмнэлгийн хэрэгсэл, үнэ төлбөргүй шилжүүлсэн вакцин, эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай болон санхүүгийн тайлангийн оршин байх, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2. Эрсдэл:

Тендерийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авалтыг цахим баримтаар баримтжуулаагүй байх

2.3. Өгсөн зөвлөмж:

Тендерт шалгарсан бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай хийх худалдан авах гэрээндээ цахим баримтын талаар тусган, худалдан авалт хийх бүрдээ баримтжуулж ажиллах ба сумдад олгосон тооцоог сар улирлаар хийж хэвших

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.12.31			ТӨА-2021/202/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Төв аймгийн Эрүүл мэндийн газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	АБ-аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хавсран ажилласны нэмэгдлийг олгохдоо 3 хүнд 405.6 мянган төгрөгийг илүү олгосон байна.	405.6	Төлбөрийн акт	Дарга Ня-бо	С.Мөнхтуяа Б.Төмөрчөдөр
2	Бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн худалдан авалтын гэрээ хугацаа хэтэрсэн, гэрээний нөхцөл хангалтгүй, гэрээ дүгнээгүй.	0	Албан шаардлага	Дарга Ня-бо	С.Мөнхтуяа Б.Төмөрчөдөр
3	Санхүүгийн тайлангаарх 2,150.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн акт баримтжуулаагүй, тооцоо нийлсэн актад тооцооны баримтын жагсаалтыг бичээгүй, ХӨСҮТ-тэй тооцоо нийлсэн актын мэдээлэл 6,622.2 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	8772.2	Албан шаардлага	Дарга Ня-бо	С.Мөнхтуяа Б.Төмөрчөдөр
4	Эрүүл мэндийн газарт батлагдсан сумдын эмийн төсвөөс хэмнэгдсэн үлдэгдэл 66,844.7 мянган төгрөгийг 26 сумын ЭМТ-д шилжүүлсэн.	66844.7	Зөвлөмж	Дарга Ня-бо	С.Мөнхтуяа Б.Төмөрчөдөр
5	Эмийн зарлагын гүйлгээг журналын дүнгээс хөөн шалгахад зөрүүтэй, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн анхан шатны баримт алдаатай, цахим баримтаар бүрэн баталгаажаагүй.	0	Зөвлөмж	Дарга Ня-бо	С.Мөнхтуяа Б.Төмөрчөдөр
6	Санхүүгийн тайланд илэрсэн 6 алдааг аудитын явцад залруулсан.	2069670.8	Залруулсан	Дарга Ня-бо	С.Мөнхтуяа Б.Төмөрчөдөр
ДҮН		2145693.3			

АУДИТЫН ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

